

*Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн “САНХҮҮ БҮРТГЭЛИЙН
АЛБАНЫ ДАРГА”- ын албан тушаалын сонгон шалгаруулалтыг зарлаж байна.*

Гүйцэтгэх үндсэн үүрэг:

Төсөв санхүүгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгууллагын төсвийн орлого, зарцуулалтын үйл ажиллагаа, төрийн болон орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалтад хяналт тавих, удирдлагад мэргэшил аргазүйн дэмжлэг үзүүлж үнэн бодит мэдээллээр хангах, санхүүгийн эрсдлээс сэргийлэх, чиг үүргийн хүрээнд байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийн үр дүнг байгууллагын захирлын өмнө хариуцна.

Ажлын байранд тавигдах ерөнхий шаардлага :

Боловсрол:

Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэглэлээр төгссөн байх

Мэргэжил:

Санхүү/041201/

Нягтлан бодох бүртгэл /041101/

Эдийн засагч/0311/

Мэргэшил:

Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтад хамрагдаж, төгссөн байх

Эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй байх

Туршлага:

Нягтлан бодогчоор 5-аас доошгүй жил, үүнээс шууд захирагчийн ахлах нягтлан бодогч, эсвэл төвлөрүүлэн захирагчийн нягтлан бодогчийн ажлыг 3-аас доошгүй жил гүйцэтгэсэн, туршлагатай байх

Ажлын байранд тавигдах тусгай шаардлага:

-Нягтлан бодох бүртгэлийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тусгай зөвшөөрөлтэй программ хангамжийг бүрэн ашиглах чадвартай байх

Сонгон шалгаруулалт явуулах хугацаа:

-Сонгон шалгаруулалт явуулах өдрийг жич зарлана. /Бүртгэлийн өдөр зарлана./

Сонгон шалгаруулалтад орох иргэнийг бүртгэх:

- 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 10:00 цагаас
- 2025 оны 06 дугаар сарын 27 өдрийн 17:00 цаг хүртэл бүртгэнэ.

Сонгон шалгаруулалтад бүртгүүлэхдээ дор дурдсан материалыг бүрдүүлэн авч ирнэ.

- Төрийн албан хаагчийн анкет /Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын Маягт I-ээр/
 - Ажил хүссэн өргөдөл
 - Төгссөн их, дээд сургуулийн диплом, бакалаврынхуулбар
 - Урьд нь ажиллаж байсан ажлын газрын тодорхойлолт
 - Иргэний үнэмлэхийн хуулбар
 - Эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогч зэрэгийн үнэмлэхний хуулбар
 - 4х6 цээж зураг 1 хувь
- Дээрхи шаардлага хангасан материалыгХүний нөөцийн албанд авчирч өгнө

Мэдээлэл, лавлагаа:

“Санхүү бүртгэлийн албаны дарга”-ын сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг Орхон аймаг БОЭТ-ийн www.orkhonboet.moh.gov.mn сайтны “Хүний нөөц” цэсний Нээлттэй ажлын байр хэсэг-ээс авч болно